

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 06

Баянцагаан

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГ

1.1 Орлоготой иргэн


- 1.1.1 Сумын хэмжээнд иргэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн богино хугацааны сургалтуудыг жил бүр зохион байгуулж чадваржуулна.
- 1.1.2 Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Сумын хэмжээнд байнгын шинэ ажлын байр бий болгосон үйлдвэрлэгчдийг ажлын байраар хангах, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, хөнгөлөлттэй зээл, төслөөр дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.4 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 1.1.5 Хөдөө орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ
- 1.1.6 Иргэдийн туршлага ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно.

1.2 Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх

- 1.2.1 Сумын төвийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй орон сууцны тоог нэмэгдүүлнэ.
- 1.2.2 Малчдын дундын сан байгуулах арга хэмжээг үргэлжлүүлэн хуримтлалыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

1.3 Эрүүл иргэн

- 1.3.1 Эрүүл мэндийн төвийг эхо аппарат, цогцос хадгалах хөргүүр, гал тогооны болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- 1.3.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг жил бүр зохион байгуулна
- 1.3.3 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн үзлэг оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.4 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, орон нутгийн оношилгоо мэдээллийг дээд шатлалын эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.5 “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, ур чадварыг тасралтгүй дэмжиж, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулан “Цогц чадамжтай эмч” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



Handwritten signature
000000001



1.4 Чанартай боловсрол

- 1.4.1 Цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж сургалтын орчныг сайжруулна.
- 1.4.2 Спорт заалны сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж сурагчдын сурах орчныг сайжруулна.
- 1.4.3 Шинэ сургуулийн дотоод тохижилтыг бүрэн хийнэ.
- 1.4.4 Биеийн тамирын гадаа талбайг тохижуулж, сурагчдын бие бялдрыг хөгжүүлнэ.
- 1.4.5 Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.6 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5 Тогтвортой - Амар амгалан гэр бүл

- 1.5.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.5.2 Хөдөлмөр эрхлэлт зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.
- 1.5.3 Гэр бүл дэх эцэг эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.6 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

- 1.6.1 Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшлийг сайжруулах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.2 Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна
- 1.6.3 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж хяналтыг сайжруулна

1.7 Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.7.1 Залуу гэр бүлийг эдийн засгийн бодлогоор дэмжиж гэр бүлийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 1.7.2 Нийгмийн салбарын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 1.7.3 Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ

1.8 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих


- 1.8.1 "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.8.2 Төрийн үйлчилгээний байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.9 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

- 1.9.1 Ахмад настнуудын ажил амьдралын баялаг туршлагыг бусдад өвлүүлэн сургах, тэднийг халамжлах, сэтгэл хангалуун өөдрөг байлгах зорилго бүхий "Ахмадын өргөө"-г барьж, хамтран ажиллана.
- 1.9.2 Ахмадын зөвлөх үйлчилгээг салбар бүрд хэрэгжүүлнэ
- 1.9.3 Ахмад настнуудад чиглэсэн олон талт нийгмийн үйлчилгээг зохион байгуулна.

1.10 Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.10.1 Шагайн харваа, сурын харвааны холбоодыг дэмжиж, шаардлагатай хэрэглэгдэхүүнд дэмжлэг үзүүлнэ.


 000005002

41714
 00067


- 1.10.2 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.10.3 Соёлын төвийг тавилга, эд хогшил, сандал ширээ, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.
- 1.10.4 Бүх ард түмний урлагийн наадмыг жил бүр зохион байгуулж ардын авьяастныг төрүүлнэ.
- 1.10.5 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж Соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ
- 1.10.6 Цахим номын сан байгуулж иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр түгээн дэлгэрүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах Мал нядлах, савлах үйлдвэр байгуулна.
- 2.2 Арьс шир нэхий боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.3 Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, блокийн үйлдвэрлэлийг өргөтгөх замаар барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ
- 2.4 Сумд аяллын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох, "Хот айл-жуулчны бааз" төсөл хэрэгжүүлж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ
- 2.5 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана
- 2.6 Орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийг ая тухтай орон сууцаар хангана.
- 2.7 Сумын төвд 2 км автозам барих ажлыг хийнэ.
- 2.8 Сумын төвийн эрчим хүчний шугам сүлжээний өргөтгөх ажлыг зохион байгуулна.
- 2.9 Онцгой байдлын аврах бүлгийн байрны өргөтгөл засварын ажлыг хийж, гал унтраах машинаар хангана.
- 2.10 Гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтыг хийж гүйцэтгэнэ

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн "Нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр, төрийн албан хаагчийн "Сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлж, "Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.
- 3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.
- 3.3 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.
- 3.4 Нутгийн удирдлагын ордон шинээр барьж ашиглалтад оруулна.
- 3.5 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.6 Шаардлагатай төрийн байгууллагуудад тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийнэ.


000000003

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



- 4.1 Байгалийн усыг тогтоож хөв цөөрөм байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэнэ.
- 4.2 Байгаль орчны салбарын ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлж, унаа, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- 4.3 Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана.
- 4.4 Аргалант ууланд газрын Генератор байрлуулна.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Мал угаалгын ванны тоог нэмэгдүүлнэ
- 5.2 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч шинээр гүн өрмийн худаг гаргаж, хувийн хөрөнгөөр гүн өрмийн худаг, гар худаг гаргасан иргэдийг урамшуулна
- 5.3 Цагдуултайн услалтын системийг сайжруулан тариалалтыг нэмэгдүүлж, тэжээлийн үйлдвэр байгуулна.
- 5.4 Улаан шалын хоолойг усжуулж, орон нутгийн отрын бүс байгуулна.
- 5.5 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 5.6 Нутгийн шилмэл омог, үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, тааварлаг чанарыг сайжруулна.

МЭДЭЭЛЛИЙГ БИЧСЭН

БАЯНЦАГААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ

ДЭД ДАРГА

Г.ЭНХБАЯР

000000004